



ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
X Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 79

Эрдэнэ-Уул

Төсөл сонгон шалгаруулах хороо

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах ажлын хэсгийн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга: Л.Дашлхагва /ЗДТГ-ын дарга/

Гишүүд: Ч.Хишиглхам /Төрийн сангийн мэргэжилтэн/

Ц.Жанцандолгор /ТББ-ийн төлөөлөл/

Д.Ариунзаяа /Иргэний төлөөлөл/

Нарийн бичгийн дарга: Г.Энхтамир /Хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн/

2.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах талаарх мэдээллийг хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгох журамд заасан шалгуур хангасан хоршоо, иргэн болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд шуурхай хүргэж, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг ил тод, нээлттэй шалгаруулж, үр дүнтэй хэрэгжүүлж зохион байгуулж ажиллахыг хорооны нарийн бичгийн дарга (Г.Энхтамир)-д үүрэг болгосугай.

3.Төсөл сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг сайтан хангаж ажиллахыг Хорооны бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГА

Т.БААСАНСҮРЭН

